

ХУДГИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОН ШААРДЛАГА

/Үзүүлэлтүүд/

№	Худгийн цооног өрөмдөх тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага стандартыг дагаж мөрдөнө.
1	Цооног өрөмдөх, цооногийг тоноглох
1.2	Цооногийн ашиглалтын ундарга: цагт 2м ³ -6м ³ ус өгөх хүчин чадалтай байна.
1.3	Суултын яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн олон улсын ISO гэрчилгээтэй байна.
1.4	Шүүрийн яндангийн материал нь ган, хуванцар хоолой байх ба ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн олон улсын гэрчилгээтэй байна.
1.5	Ус өргөх яндангийн диаметр 32мм-ээс багагүй материал нь төмөр болон ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой / муфт, угольник, тройник/ гэх мэт ISO стандарт хангасан хүйтний улиралд тэсвэртэй
1.6	Ус шүүх хайрга нь шигшсэн мөлгөр хэлбэртэй тоосонцор хольцгүй мөхлөгийн хэмжээ 10-15мм томгүй байна.
1.7	Тунгаагуурын гүн: 2 метрээс багагүй байна.
1.8	Худгийн шавхалт хийж цэвэрлэх хугацаа: 24 цагаас багагүй
1.9	Усны чанарын сорилт шинжилгээ хийлгэх
1.10	Худгийн цооногийг таглаж тоноглосон байна.
2	Цахилгаан үүсгүүр , худгийн ус шахуурга, ус өргөх хоолой , шүүр яндан
2.1	Цахилгаан үүсгүүр нь чанарын гэрчилгээтэй холбогдох олон улс болон үндэсний стандартын шаардлага хангасан байна. /220В 4500 багагүй мотор/
2.2	Худгийн шахуургын хөдөлгүүр: ISO9001:2015 стандартын шаардлага хангасан байх , Ус шахуургын хөдөлгүүр нь EN 60335 -1, 2012 + A11 2014, AC:2014 стандартын шаардлага хангасан , 3 салаа цахилгааны утастай байна. Ус шахуурга нь 2022 онд үйлдвэрлэсэн байх /гарал үүслийн гэрчилгээг хавсаргах/
2.3	Цахилгааны утас: IEC 60227-5 болон ISO 9001:2015 чанарын стандарт хангасан. VCMF эсвэл түүнтэй дүйцэхүйц загварын 3 салаатай ус чийгээс хамгаалагдсан давхар бүрээстэй цооногт устай нөхцөлд ашиглах шаардлагыг хангасан байх , утас нь залгаасгүй үргэлжилсэн байх
2.4	Ус өргөх хоолой: GB/T18977.1-2002 стандартын шаардлага хангасан, зориулалтын түүхий эдээр хийгдсэн доод тал нь 1.0 МПас-аас багагүй даралт даах чадвартай , цагаан өнгийн , дотор давхарга нь тунгалаг ундны ус дамжуулах зорилготой байх. Хоолойн диаметр 32мм-ээс багагүй байх
2.5	Худгийн шүүр яндан: 100м хүртэл гүнтэй цооног дахь шүүрийн яндангийн гадаад диаметр нь 127мм-ээс дээш байна. Хуванцар хоолой нь анхдагч түүхий эд ашиглаж үйлдвэрлэсэн, MNS5544:2007 чанарын шаардлага хангасан, ундны усны шаардлага хангасан, лаборторын шинжилгээтэй байна. Эргэлтэт, цохилтот өрөмдлөгийн аргаар өрөмдсөн цооног дахь шүүрийн янданд ус нэвтрүүлэх шүүрийг зориулалтын төхөөрөмжөөр хөндлөн байдлаар нэг эгнээнд 8-10 ширхэг, 40-80мм хэмжээтэй цуулбарлан ашиглаж болно. Хоолойн зузаан нь 3мм ээс багагүй байна.
3	Худаг хүлээлгэн өгөх
3.1	Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх / талбайг цэвэрлэх /
3.2	Худгийн насос, мотор ажиллуулах, үйлчилгээ хийх, заавар гарын авлага өгөх
3.3	Акт материалууд, техникийн паспорт бэлтгэх байгаль орчны газраар баталгаажуулж хүлээлгэн өгөх



ГҮН ӨРМИЙН ХУДАГ ШИНЭЭР ГАРГАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2023 оны 5 сарын 24

Мөнххаан

Байршил: Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг дэвсгэрт 2ш гүн өрмийн худаг шинээр гаргах

1 Ажлын тодорхойлолт:

2.Худгийг шинээр гаргахаас өмнөх ба дараах үеийн гэрэл зургийг нэг цэгээс авч худгийн солбилцолыг нарийвчлан тодорхойлсон байна.

3. Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага стандартын дагуу өрөмдлөг, шавхалт, туршилтийн ажлыг явуулах, худгийн усны шахуурга, цахилгаан үүсгүүрийг сонгон суурилуулах ажлыг гүйцэтгэнэ.

4. Монгол Улсын Хөдөө Аж Ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 101/189/194 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам" -ыг мөрдөнө. Үүнд: .

- Ажлын иж бүрдэлд цооног өрөмдөх, цооногийг цэвэрлэх, шавхалт туршилтын ажил хийх, ус шахуурга, цахилгаан үүсгүүр суурилуулах зэргийг барьж байгуулах ажлыг багтаана.
- Гүн өрмийн худаг уст цэгийг шинээр гаргах тухай ажлын төрөл хэмжээ өртөгийг тогтооно.
- Гүн өрмийн худаг уст цэгийг шинээр гаргах тухай , гэрээт хугацааны дотор актыг үйлдэж хүлээлгэн өгсөн тухай Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын ажлын хэсгийн акт 2 хувийг үйлдэж, сумын Засаг даргын тамгын газарт хүлээлгэн өгч, орон нутгийн өмчид тусгуулна.
- Шинээр худаг гаргах гэж байгаа бол өрөмдөхийн өмнө хайгуулын ажлаар устай эсэхийг тогтоосон акт үйлдэнэ.
- Ус багатай бол өрөмдөх шаардлагагүй, дахин хайгуул хийнэ.
- Худгийн цооног өрөмдлөгийн ажлын талаарх мэдээллийг өрөмдлөгийн ажлын журналд тэмдэглэнэ.
- Өрөмдлөгийн ажлыг дууссаны дараа шавхалтын ажлыг заавал хийж, шавхалтын ажлын журналыг дэлгэрэнгүй үйлдэнэ. Худгийн техникийн паспортыг хөтөлж, аймгийн БОАЖГ азраар баталгаажуулан, сумын Засаг даргын тамгын газарт хүлээлгэн өгнө.
- Гүн өрмийн худаг, уст цэгийг шинээр гаргасан далд ажлын тухай Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын ажлын хэсгийн акт 2 хувийг, тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн актын хамт үйлдэж суманд хүлээлгэн өгнө.
- Гүн өрмийн худгийн усны шахуурга, шахуургын цахилгаан үүсүүр, цахилгааны утас, холбогч хэрэгсэл, дагалдах зүйлсийг иж бүрнээр худгийн цооног бүрт суурилуулна. Худгийн усны шахуурга дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: Гарал үүслийн гэрчилгээтэй үйлдвэрлэгчийн нэр хаяг барааны олон улсын гэрчилгээтэй байх
- Усны химийн болон бактериологийн шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж дүгнэлт гаргуулан авах